

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ ОРЧИН, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин /Тоо хэмжээ, хувь/	Хүрсэн түвшин /Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэл /мян.төг/	Тайлбар
Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоодын сургалтын тоо	10-аас дээш	100 хувь /48 удаагийн сургалт/	87 удаагийн сургалт 100 хувь	Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Архивын ерөнхий газар, Нийслэлийн Архивын газар, “Нийслэлийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж болон eDoc системийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр цахим сургалт”, “Өргөдөл, гомдлын асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжил арга зүйн сургалт” зэрэг 87 удаагийн сургалтад (цахимаар 45, танхимын 42) давхардсан тоогоор 651 албан хаагч (100 хувь) хамрагдав. Ажлын байранд Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, JCI ТББ, Super Jump сургалтын байгууллагатай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулав. Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн нийт 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 359 албан хаагч ажлын байранд цахимаар хамрагдсан байна. Z:\0.KHOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR\8. HUNII NUUTSIIN MEDEELEL\2022.

			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	100 хувь /302 албан хаагч/	100 хувь 651 албан хаагч	Нийт 87 удаагийн сургалтад (цахимаар 45, танхимын 42) нийт давхардсан тоогоор 651 албан хаагч хамрагдав. Үүнээс 4 цагаас дээш 45 удаагийн сургалтад давхардсан тоогоор 123 албан хаагч хамрагдсан байна. Эрэгтэй албан хаагчийн тоо 55, эмэгтэй албан хаагчийн тоо 68
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	10 хувиас дээш	2 хувь 2 албан хаагч	9.7 хувь 8 албан хаагч	Гадаад улсад зохион байгуулагдсан сургалт, семинар, хурал зөвлөгөөнд Газрын даргын тушаалаар 6 удаагийн сургалтад 8 албан хаагч хамрагдав. - БНСУ-д “Түрээсийн орон сууцны бодлого, санхүүжилт” сэдэвт сургалтад 1 албан хаагч, - БНСУ-д “Нийтийн орон сууцны барилгын зураг төсөл, төслийн менежмент” сэдэвт сургалтад 1 албан хаагч, - БНСУ-д Солонгосын Архитектурын хүрээлэнгээс зохион байгуулсан “KIA Convention & Exhibition 2022” үзэсгэлэн, хурал, семинарт 2 албан хаагч, - Филиппин улсад “Улаанбаатар хотын захиргааны албан хаагчдад зориулсан Азийн хөгжлийн банкны хамгаалалтын бодлого” сургалт, танилцах аялалд 2 албан хаагч, - Япон улс, “Japan Build Expo 2022” танилцах аяллын хөтөлбөрт 1 албан хаагч , - Сингапур улс, “Олон улсын залуу архитектор, хот төлөвлөгч, салбарын мэргэжилтнүүдийн төслийн танилцуулга, чөлөөт уулзалт”-д 1 албан хаагч тус тус хамрагдав.
			3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	85 хувь /76 албан хаагч	79 хувь	Нийт албан хаагч 91, үүнээс одоо ажиллаж байгаа 81, хүүхэд асрах чөлөөтэй 10 албан хаагч байна. Мэргэжлийн хувьд: Архитектор 22, хот ба бүс нутаг төлөвлөгч 7, инженер 19, газар зохион байгуулагч 18, эдийн засагч 6, хуульч, эрх зүйч 10, бусад мэргэжлийн 9 байна. Барилга, архитектур, инженерийн мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 74% байгаа нь газрын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн ажилтнуудаар бүрэн хангагдсан байна. Албан хаагчдын мэргэшсэн байдал: Зөвлөх архитектор 4, зөвлөх инженер 3, мэргэшсэн архитектор 15, мэргэшсэн инженер 14, мэргэшсэн эдийн засагч 4, мэргэшсэн хуульч 1, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин 1. Албан хаагчдын ажилласан жилийн үзүүлэлт:
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөц бүрдүүлэх						

						1. Улсад ажилласан жилээр: 1-5 жил ажилласан 20 албан хаагч, 6-10 жил ажилласан 28 албан хаагч, 11-15 жил ажилласан 18 албан хаагч, 16-20 жил ажилласан 13 албан хаагч, 21-ээс дээш жил ажилласан 12 албан хаагч. Мэргэжлээрээ буюу улсад 5-аас дээш жил улсад ажилласан 72 ажилтан буюу эзлэх хувь 79 байна. 2. Төрийн албанд ажилласан жилээр: 1-5 жил ажилласан 26 албан хаагч, 6-10 жил ажилласан 29 албан хаагч, 11-15 жил ажилласан 19 албан хаагч, 16-20 жил ажилласан 10 албан хаагч, 21-ээс дээш жил ажилласан 7 албан хаагч. Төрийн албанд 5-аас дээш жил ажилласан 66 ажилтан буюу эзлэх хувь 73 байна. 3. Тухайн байгууллагад ажилласан жилээр: 1-5 жил ажилласан 37 албан хаагч, 6-10 жил ажилласан 33 албан хаагч, 11-15 жил ажилласан 17 албан хаагч, 16-20 жил ажилласан 3 албан хаагч, 21-ээс дээш жил ажилласан 1 албан хаагч. Тухайн байгууллагад 5-аас дээш жил ажиллаж байгаа 54 ажилтан буюу эзлэх хувь 59 хувь байна. 5-аас дээш жил ажилласан ажилтны эзлэх хувь 79% байгаа нь дадлага, туршлагатай болон шинэ залуу ажилтны зохистой хослол бүрдсэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/641 дүгээр захирамжаар 29 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 4 албан хаагчид зэрэг дэвийг шинээр олгов. Төрийн захиргааны 63 албан хаагч буюу 67% зэрэг дэвтэй байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн 63 албан хаагч, 2022 онд нэр дэвшсэн 14 албан хаагч тангараг өргөхөөр хүлээгдэж байна. Доктор 1, Магистр 25, бакалавр 65.
	Хэсгийн дундаж 100 хувь					
Албан хаагчдын	3	Цалин хөлс, шагнал,	Шагнал, урамшуула	Гүйцэтгэл	46 албан хаагч	Төрийн албаны тухай хууль, Газрын Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу Газрын даргын 7 удаагийн

нийгмийн баталгааг хангах		урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	лд хамрагдсан албан хаагчдын тоо	ээр	шагналд тодорхойлж 76 албан хаагч тэтгэмж олгов.	тушаалаар давхардсан тоогоор 76 албан хаагчид 7,200.000 төгрөгийн тэтгэмжийг олгов. Нийслэлээс Онцгой комиссын шуурхай штабын Орон зайн дүн шинжилгээний багт ажиллаж байгаа 2 албан хаагчид 2022 оны эхний 3 сарын илүү цагийн нэмэгдэл, нийслэлийн удирдлагаас тусгайлан өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 8, 9, 15-ны өдөр, 2 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд ажилласан нийт 77 албан хаагчид Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу нэмэгдэл цалин хөлсийг тус тус олгов. 2022 онд нэгж, хамт олноо манлайлан, амжилттай ажилласан 11 албан хаагчид тус бүр 1,000,000 төгрөгийн, нийт 11,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгов. 2022 оны Ардын хувьсгалын 101 жилийн ой, Улсын их баяр наадам, Нийслэл Улаанбаатар хот үүсэж хөгжсөний 383 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын ажилд дорвитой хувь нэмэр оруулж, хот байгуулалт, газрын харилцааны салбарт тогтвор суурьшилтай, идэвх санаачилгатай амжилт гарган ажилласан албан хаагчдыг зохих журмын дагуу шагналд 65 албан хаагчийг нэр дэвшүүлж тодорхойлсноос 12 нэр төрлийн шагналаар 59 албан хаагчийг шагнуулав..
2.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			Албан хаагчдын үйл ажиллагаа ны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв шатлал ахиулах	Гүйцэтгэ л ээр	100 албан хаагч	Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сүүлийн гурван жил дараалан “А” үнэлэгдсэн 21 албан хаагчид цалингийн шатлалыг алгасуулан, 3 албан хаагчийг ажилласан жилээр тус тус нэмэгдүүлж, 8 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ахиулж, шинээр 11 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож, бусад ур чадварын нэмэгдлийг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу нэмэгдүүлж Газрын даргын 2022 оны Б/07 дугаар тушаалаар цалинг шинэчлэн батлуулав. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/641 дүгээр захирамжийг үндэслэн 34 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоов.

	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	80 хувь	—	Газрын даргын 2022 оны А/08 дугаар тушаалаар байгуулсан Газраас үзүүлж буй ажил, үйлчилгээний гүйцэтгэл, түвшний талаарх сэтгэл ханамжийн байдлыг судлах судалгааны багаас цаасан суурьтай судалгаа болон “google ашиглан цахим судалгааг авч байна.
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	1 албан хаагчид өдөрт олгох хоолны мөнгө 4500 төгрөг, унааны зардал 500 төгрөг	88 албан хаагч	Нийслэлээс баталсан төсвийн хүрээнд нэг албан хаагчид өдрийн хоолны мөнгө 4500 төгрөг, унааны зардал 500 төгрөгийг тус тус олгож байна.
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	100 албан хаагч	12.900.0	Газрын даргын 2021 оны Б/58 дугаар тушаалаар газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд 86 албан хаагчийг хамруулж, Сөүл эмнэлэгтэй гэрээ байгуулав. Нэг хүний 150000 төгрөг, нийт 12.900,000 төгрөгийг шийдвэрлүүлэв. Эмнэлгийн үзлэг шинжилгээнд 86 албан хаагч хамрагдав. 2022 онд албан хаагчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төсөв батлагдаагүй болно.
			Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100 хувь		

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ч.БАДАМХАНД

Т.БУЯНЖАРГАЛ